



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДУГНЭЛТ**

131 дүгээр байшин, Эрүүл мэндийн гудамж, 2 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44105
Утас/факс: (976) 7052 2349

Цахим шуудан: emg.dornogovi@gmail.com

2023. 10. 13 № 10-21-021089/87

**ЛАНД БИМИОН КОНСТРАКШН
ХХК-НЫ ЗАХИРАЛ Д.МӨНХТУЛГА ТАНАА**

Барилга байгууламжийн ажлын
зураг төсөлд баталгаажуулах
хяналт хийсэн тухай

Ланд бимион констракшн ХХК-ийн захиралын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 33/23 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих 3 дугаар ээлжид хэрэгжүүлэх, Дорноговь аймгийн Өргөн, Сайхандулаан сумдын засварын ажлын зураг төсөлд Эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтооолор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтаар баталгаажуулах хяналтыг хийж гүйцэтгэлээ.

Тус сумдын сургалтын байгууллагын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын зураг төслийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэгт байрлах тусгай зөвшөөрөл бүхий Ланд бимион констракшн ХХК /9011767011 улсын бүртгэлийн дугаартай, 6350232 регистрийн дугаартай/ боловсруулсан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын 4 дүгээр багт байрлах ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг бохир ус цэвэрлэх бага оврын байгууламжтай байхаар төлөвлөсөн, цэвэрлэх байгууламжийн талбайн инженер геологийн судалгааг Энх-өрнөлт ХХК-ны инженер, техникийн ажилчид 2023 оны 07 дугаар сарын 03-аас 07 дугаар сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэн дүгнэлт гаргасан.

Дээрх дүгнэлтэд инженер геологийн дунд зэргийн нөхцөлтэй, судалгааны талбайд хөрсний ус илрээгүй, судалгааны талбай газар чичирхийлэлийн 500 жил 6 баллын бүсэнд хамарагдана гэж дурьдсан.

Дотуур байрны ариун цэврийн өрөөг бүрэн засварлаж, төлөвлөлтөөр 1 дүгээр давхарт эмэгтэй, эрэгтэй сурагчдын усанд орох өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэний угаалтуур, суултуур, 2 дугаар давхарт /3 суултуур, 3 угаалтуур/, бага насны хүүхдийн угаалтуур суултуур, ханад гар хатаагч байхаар төлөвлөсөн.

Ариун цэврийн байгууламжийн хувьд эмэгтэй сурагчдын бие засах суултуур, угаалтуурын хэмжээг тусгаагүй, кабиныг шалны түвшнээс дээш 10см, өндөр-2.0м, өрөөнд орох, гарах хэсгийн хаалганы өргөн-80см, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний хаалганы өргөн, өндөр, хаалганы бариулын өндөр, ариун цэврийн өрөөний хана, шалны өнгө тодорхойгүй.

Халаалт агаар сэлгэлтийн хувьд ариун цэврийн өрөөг халаах эх үүсвэр нь тодорхойгүй, агаар сорох механик системтэй, хэрэгцээний халуун усыг цахилгаан

эзэлхүүний ус халаагчаар хангагдах, гол барилга байгууламжаас бохир усны худаг-№1 нь 10метр, өрөөнд зохиомол гэрэлтүүлэгтэй.

Сургуулийн өөрийн эх үүсвэрээс цэвэр усаар хангах бөгөөд цэвэршүүлэх шүүх төхөөрөмжтэй байхаар төлөвлөгдсөн, бохир ус цэвэрлэх ажиллагаа тодорхойгүй.

Дунд сургуулийн байранд байгаа ариун цэврийн өрөөг бүрэн засварлаж, төлөвлөлтөөр эрэгтэй сурагчдын ариун цэврийн өрөө /2 суултуур, 2 угаалтуур, 1 шээлүүр/, эмэгтэй сурагчдын ариун цэврийн өрөө /3 суултуур, 3 угаалтуур/, ариун цэврийн өрөө бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон бага насы хүүхдийн угаалтуур суултуур төлөвлөсөн.

Ариун цэврийн байгууламжийн хувьд эмэгтэй сурагчдын бие засах суултуур, угаалтуурын хэмжээг тусгаагүй, кабиныг шалны түвшнээс дээш 10см, өндөр-2.0м, өрөөнд орох, гарах хэсгийн хаалганы өргөн-90см, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний хаалганы өргөн, өндөр, хаалганы бариулын өндөр, ариун цэврийн өрөөний хана, шалны өнгө тодорхойгүй.

Халаалт агаар сэлгэлтийн хувьд ариун цэврийн өрөөг халаах эх үүсвэр нь тодорхойгүй, агаар сорох механик системтэй, хэрэгцээний халуун усыг цахилгаан эзэлхүүний ус халаагчаар хангагдах, гол барилга байгууламжаас бохир усны худаг-№1 нь 5метр, өрөөнд зохиомол гэрэлтүүлэгтэй.

Дорноговь аймгийн Өргөн сумын 4 дүгээр багт байрлах, ерөнхий боловсролын сургуулийг стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн ажлын зургын төлөвлөлтөөр эрэгтэй сурагчдын ариун цэврийн өрөө /2 суултуур, 2 угаалтуур, 3 шээлүүр/, эмэгтэй сурагчдын ариун цэврийн өрөө /4 суултуур, 3 угаалтуур/, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ариун цэврийн өрөө, багш ажиллагсдын ариун цэврийн өрөөг тус тус төлөвлөсөн.

Ариун цэврийн байгууламжийн хувьд эмэгтэй сурагчдын бие засах суултуур, угаалтуурын хэмжээг тусгаагүй, кабиныг шалны түвшнээс дээш 10см, өндөр-2.0м, өрөөнд орох, гарах хэсгийн хаалганы өргөн-80см, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний хаалганы өргөн-1.10см, өндөр, хаалганы бариулын өндөр, ариун цэврийн өрөөний хана, шалны өнгө тодорхойгүй.

Ус хангамж, ариутгах татуурга, халаалтын төвлөрсөн системд холбогдсон, ариун цэврийн өрөөнд агаар сорох механик системтэй, гол барилга байгууламжаас бохир усны худаг хүртэлх зайд хэмжээ тодорхойгүй, өрөөнд байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй.

Дотуур байрны ариун цэврийн өрөөг бүрэн засварлаж, төлөвлөлтөөр 1 дүгээр давхарт эмэгтэй, эрэгтэй сурагчдын ариун цэврийн өрөө /тус бүр 3 угаалтуур, 3 суултуур/, хөгжлийн бэрхшээлтэй иргэний угаалтуур, суултуур, 2 дугаар давхарт эрэгтэй ариун цэврийн өрөө /3 суултуур, 3 угаалтуур, 1 шээлүүр/, угаалга, 2 кабинтай шүршүүрийн өрөө, 3 дугаар давхарт /3 суултуур, 3 угаалтуур/, угаалга, 2 кабинтай шүршүүрийн өрөө, ариун цэврийн өрөө бүрд гар хатаагч байхаар төлөвлөсөн.

Ариун цэврийн байгууламжийн хувьд эмэгтэй сурагчдын бие засах суултуур, угаалтуурын хэмжээг тусгаагүй, кабиныг шалны түвшнээс дээш 10см, өндөр-2.0м, өрөөнд орох, гарах хэсгийн хаалганы өргөн-81см, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний хаалганы өргөн-120см, өндөр, хаалганы бариулын өндөр, ариун цэврийн өрөөний хана, шалны өнгө тодорхойгүй.

Ариун цэврийн өрөөнүүд нь агаар сорох механик системтэй, гол барилга байгууламжаас бохир усны худаг хүртэлх зайд хэмжээ тодорхойгүй, өрөөнд байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй.

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах заалтыг үндэслэн **ДҮГНЭХ НЬ:**

Дорноговь аймгийн Өргөн сумын ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлын зурагт ариун цэврийн байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ариун цэврийн ерөөг тусгай хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тоноглосон, хэрэглээний халуун хүйтэн усаар хангах эх үүсвэртэй, халаалалтын нэгдсэн системд холбогдохоор төлөвлөгдсөн.

Сайхандулаан сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны усан хангамж нь өөрийн эх үүсвэртэй, бохир ус цэвэрлэх бага оврын ариун цэврийн байгууламжтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ариун цэврийн өрөөг тусгай хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тоноглосон байгаа нь "Олон нийт иргэний барилга" /БНБД 31-03-03/, "Иргэний барилгын төлөвлөлтэд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зайд, орчин"-. MNS 6055:2009 стандарт, БСШУ-ны сайд, ЭМС-ын Сайд, Сангиин сайдын 2015 оны А/253/251/173 тоот хамтарсан тушаалын хавсралтын 1.2, 2, 3 дахь хэсэг, өргөтгөх засварлахаар төлөвлөсөн ариун цэврийн өрөөнд агаар сорох механик системийг төлөвлөсөн, байгалийн гэрэлтүүлэг хүрэлцээтэй байгаа нь Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг болон Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартыг тус тус хангаж байна.

Ариун цэврийн байгууламж болох эмэгтэй сурагчдын бие засах суултуур, угаалтуурын хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний хаалганы бариулын өндөр, ариун цэврийн өрөөний хана, шалны өнгийг ажлын зурагт тодорхой тусгах.

Сайхандулаан сумын дотуур байрны халаалт, сургуулийн цэвэр усны хангамж, бохир ус зайлзуулж цэвэрлэх үйл ажиллагаа ажлын зурагт тусгагдаагүй.

ЭРҮҮЛ АХҮЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



Н.НЯМЦЭЦЭГ

ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН АВСАН:
ЗАХИРАЛ

Д.МОНХТУЛГА